



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эвээр засах ХХК-ийн “Вашингтон” зочид буудлын 20/379, Алтаннаран трейд ХХК “247” зочид буудлын 20/390, Алтаннаран трейд ХХК-ийн “Эрхэс” зочид буудлын 20/391, Шидэт аялгуу ХХК-ийн “Цолмон” дэн буудлын 20/398, Ган-Энх трейд ХХК-ийн “Гурван баян” дэн буудлын 20/42, Алтаннаран трейд ХХК -ийн “Мини” дэн буудлын 20/399, Кристалл клейр ХХК-ийн

“Рүүмс” дэн буудлын 20/362, Алс тэртээ ХХК-ийн “Топаз” дэн буудлын 20/334, Оршил гранд ХХК-ийн “Оршил ресорт” амралтын газрын 20/428 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Х.Содномдэмбэрэл/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.


7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д даалгасугай.

ДАРГА



А.АРИУНГЭРЭЛ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 09
сарын 30-ны өдрийн А/58 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Эвээр засах ХХК	5631858	Вашингтон	БЗД-ийн, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 41
2	Алтаннаран трейд ХХК	2548542	247	БГД-ийн, 12-р хороо, Хасбаатарын гудамж 3б
3	Алтаннаран трейд ХХК	2548542	Эрхэс	БГД-ийн, 12-р хороо, Хасбаатарын гудамж 3а
4	Саранжим ХХК	5226589	Есөн ес	БГД-ийн, 11-р хороо, 4-р хороолол, Хасбаатарын 37/1 тоот

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 09
сарын 30-ны өдрийн А/58
дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

5284325 СБТ-8936 1118203502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Шидэт аялгуу ХХК	6248853	Цолмон	СХД-ийн, 28-р хороо, Баянхошууны сансар 1-6
2	Ган-Энх трейд ХХК	2650452	Гурван баян	СХД-ийн, 18-р хороо, 5 шар Москвагийн 18 тоот
3	Гуйлан сайхан ХХК	5114985	Рич	БЗД-ийн, 21-р хороо, Бага дарь эх 6-1800
4	Алтаннаран трейд ХХК	2548542	Мини	БГД-ийн, 14-р хороо, 18/1 байр
5	Кристал клейр ХХК	5375762	Рүүмс	СБД-ийн 6-р хороо, Их сургуулийн гудамж
6	Алтан цето арван гурав ХХК	4557964	Алтан цето арван гурав	БД-ийн 3-р хороо, Нугын тал 3,1
7	Оасисмон ХХК	5678714	Оасисмон	БЗД-ийн 12-р хорооны Чулуутын 1-10
8	Супер спейс ХХК	2869268	Хан хөхий	БЗД-ийн 7-р хороо, 2-р байрны ард
9	Алс тэртээ ХХК	5392098	Топаз	БЗД-ийн, 13-р хороо, Дүүргийн 4-177 тоот

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 09
сарын 30-ны өдрийн А/58
тушаалын гуравдугаар
хавсралт

5284325 СБТ-8926 1118263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Оршил гранд ХХК	5660955	Оршил резорт	БЗД-ийн 20-р хороо, Шар хоолойн ам

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР